



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ ЯАМ

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага талруу 44, Засгийн газрын III байр  
Утас: 26-22-27, Факс: (976-11) 323589  
E-mail: info@mecs.gov.mn, http://www.mecs.gov.mn

2015-05-25 № 13/4475

танил \_\_\_\_\_ -ийн № \_\_\_\_\_ -т

Хувийн хэрэг хөтлөх зөвлөмж  
хүргүүлэх тухай

Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн суралцагчийн хувийн хэргийг Бага боловсролын сургалтын төлөвлөгөө, цөм хөтөлбөр болон Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журамтай уялдуулан хөтлөх талаар дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:


1. Суралцагчийн хувийн хэргийн "Бага боловсролын сурлагын үнэлгээ" хэсгийг хөтлөхөд:

- "Журам, заавар, загвар батлах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 361 дүгээр тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн суралцагчийн хувийн хэрэг хөтлөх заавар"-ын 3.2.1-д заасны дагуу I-II ангид "тооцов" үнэлгээг бичнэ.
- "Журам, загвар, шинэчлэн батлах тухай" Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/309 дүгээр тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам"-д III ангид анги дэвших шалгалтгүй байхаар зохицуулсан тул "Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн суралцагчийн хувийн хэрэг хөтлөх заавар"-ын 3.2.2-д заасны дагуу III ангид "тооцов" үнэлгээг бичнэ.
- "Сургалтын төлөвлөгөө, цөм хөтөлбөр, багийн бүрэлдэхүүн батлах тухай" Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/240 дүгээр тушаалаар батлагдсан Бага боловсролын сургалтын төлөвлөгөөнд тусгасан "Сургалтыг дэмжих үйл ажиллагааны үнэлгээ"-г суралцагчийн хувийн хэрэгт тэмдэглэхэд I-V анги тус бүрд "тооцов" гэсэн бичиглэл хийнэ. Тухайн үйл ажиллагааны нэр хувийн хэргийн "Хичээл" хэсэгт байхгүй тохиолдолд хоосон зайд нөхөж бичнэ.

2. Суралцагчийн хувийн хэргийн "Суралцагчийн хөгжил, төлөвшлийн тодорхойлолт" хэсэгт "Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн суралцагчийн хувийн хэрэг хөтлөх заавар"-ын 3.3-д заасны дагуу тодорхойлолт бичих бөгөөд I-III

ангийн "Суралцагчийн мэдлэг, чадварын өөрчлөлт, түүний шалтгаан" чиглэлийн тодорхойлолтод "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам"-ын 3.1-д заасан "үгэн үнэлгээ"-г багтаан бичнэ.

3. Хувийн хэргийн бусад хэсгийг түүнийг хөтлөх зааврын дагуу бүрэн хөтөлнө.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ, БАГА БОЛОВСРОЛЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА  Б. ГАНТУЛГА

